



# ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БАЛАНСЫН ХУРАЛ

---

“ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК

# АГУУЛГА

## I. Ерөнхий мэдээлэл

Компанийн товч танилцуулга

## II. Зорилтод түвшний биелэлт

- Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт
- Эдийн засгийн үндсэн үзүүлэлт

## III. Хагас жилийн тайлан

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт
- Төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тайлан
- Байгаль орчин, нийгмийн хариуцлагын тайлан
- Хууль тогтоомж, бодлого шийдвэр, үүрэг даалгаврын биелэлт
- Аудитын зөвлөмжийн хэрэгжилт


## IV. Хэрэгжилт, үр дүнгийн жил

- Онцлох ажлын тайлан
- Эхний хагас жилийн гүйцэтгэлийн дүгнэлт

## V. Тулгамдаж буй асуудал

- Асуудал шийдвэрлэх санал

# “ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



## Үүсгэн байгуулалт

Монгол Улсын Засгийн Газрын 2014 оны 133 дугаар тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолоор “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийг 2019 оны 05 дугаар сард үүсгэн байгуулсан болно. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 49 дүгээр тогтоолын дагуу “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийг “Эрдэнэс алт ресурс” ХХК-тай нэгтгэсэн.



## Чиг Үүрэг

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх
- Ашигт малтмал эрэх, хайх
- Ашигт малтмал олборлох, ашиглах
- Гэрээгээр өрөмдлөг хийх



## Ашиглалтын тусгай зөвшөөрөл

Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн хүрээнд, Засгийн Газрын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэл, Ашигт малтмал, газрын тосны газрын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 341 дүгээр шийдвэрээр Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Салхит” нэртэй 2,887.85 га бүхий ашигт малтмал ашиглах ашиглалтын МВ-021483 тоот тусгай зөвшөөрөл олгосон



## Хайгуулын тусгай зөвшөөрөл

Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 212 тоот тогтоолын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Овоот хяр нэртэй XV-21670 тоот 22641,51 га талбай бүхий хайгуулын тусгай зөвшөөрөл, Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай сумдын нутагт байрлах Өлзийт овоо нэртэй XV-021671 тоот 16634.29 га талбай бүхий тусгай зөвшөөрөл, Засгийн Газрын 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 212 тоот тогтоол, АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 308 тоот шийдвэрээр Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумдын нутагт орших “Хүрэн цав” нэртэй ашигт малтмал ашиглах ашиглалтын XV-021666 тоот тусгай зөвшөөрлүүдийг тус тус олгосон.

### Үндсэн хууль

Хуулийн 6.2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг **Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.**

### Баялгийн сангийн тухай хууль

Хуулийн 4.1.1-т "Үндэсний баялгийн сан" /цаашид "Баялгийн сан" гэх/ гэж газрын хэвлийн **баялгийн үр өгөөжийг төвлөрүүлэх, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх**, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хуваарилах, хуримтлуулах төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог.

### Ашигт малтмалын тухай хууль

4.1.25. "ашигт малтмалын ордын нөөц" гэж хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн нь нарийвчлан тогтоогдсон, үйлдвэрийн аргаар олборлох боломжтой, **эдийн засгийн үр ашигтай**, баяжуулах технологи, олборлолтын уул техникийн нөхцөл нь тодорхойлогдсон ашигт малтмалын баялгийн хэсгийг;

4.1.27. "үүсмэл орд" гэж олборлолт, боловсруулалт, баяжуулалтын явцад ялгагдсан ашигт малтмалын тодорхой агуулга бүхий дахин боловсруулахад **эдийн засгийн үр ашиг гаргаж болохуйц** хүдэр, ашигт малтмалын овоолгыг;

## УУЛЫН АЖЛЫН БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


“Эрдэнэс алт ресурс” ХХК нь 2024 онд 2,800 мян.м<sup>3</sup> уулын цул, 2,500 мян.м<sup>3</sup> хөрс хуулалт, 892.6 мян.тн хүдэр олборлохоор төлөвлөсөн.

2024 оны эхний хагас жилд нийт 1,350 мян.м<sup>3</sup> уулын цул хөдөлгөж, 1,203.6 мян.м<sup>3</sup> хөрс хуулахаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр:


- 1,329.7 мян.м<sup>3</sup> уулын цул буюу 99%, 1,176.2 мян.м<sup>3</sup> хөрс хуулалт буюу 98%, хүдэр олборлолт 386.1 мян.тн буюу 90%;
- Хүдэр дэх эрдсийн хэмжээ мөнгөний хувьд 86.1 тн буюу 86%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Үзүүлэлт	Х/н	2024 оны эхний хагас жил		Хувь	Үнэлгээ оноогоор
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Уулын цул	мян.м <sup>3</sup>	1,350.0	1,329.7	99%	4.9
Хөрс хуулалт	мян.м <sup>3</sup>	1,203.6	1,176.4	98%	4.8
Хүдэр олборлолт	мян.тн	424.9	386.1	90%	3.8
Хүдэр дэх эрдэс	Аг.тн	100.1	86.1	86%	3.3
<b>Үнэлгээний дундаж оноо</b>					<b>4.2</b>


### Уулын цул (мян.м3)



### Хөрс хуулалт (мян.м3)



### Хүдэр олборлолт (мян.тн)



### Хөрс хуулалтын коэффициент (м3/тн)



# “ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### Анхдагч хүдэр


“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн 2024 оны баяжмал үйлдвэрлэлийн төлөвлөгөөнд анхдагч хүдэр дэх мөнгөний агуулга 290 гр/тн, алтны агуулга 0.4 гр/тн 628 мян.тн хүдэр боловсруулахаар төлөвлөсөн. 2024 оны эхний хагас жилд мөнгөний агуулга 290 гр/тн, алтны агуулга 0.4 гр/тн, 272.8 мян.тн хүдэр боловсруулахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр:

- Хүдэр боловсруулалт 328.4 мян.тн буюу 120%;
- Боловсруулсан хүдэр дэх мөнгөний агуулга 288.6 гр/тн буюу 99.5%, алтны агуулга 0.4 гр/тн буюу 100%;
- Анхдагч хүдэр дэх металлын хэмжээ мөнгө 94.7 тн буюу 120%-ийн гүйцэтгэлтэй байна

Үзүүлэлт	Х/н	2024 оны эхний хагас жил			Үнэлгээ оноогоор
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
<b>Анхдагч хүдэр</b>					
Хүдэр	мян.тн	272.8	328.4	120%	5
Агуулга	Аг, гр/тн	290.0	288.6	99.5%	4.9
	Ац, гр/тн	0.4	0.4	100%	5
Металл	Аг.тн	79.1	94.7	100%	5
<b>Үнэлгээний дундаж оноо</b>					<b>4.98</b>


# “ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Боловсруулсан хүдэр (мян.тн)




НИЙТ 1,658 мян.тн

Хүдэр дэх металлын хэмжээ



Хүдэр дэх металлын агуулга (гр/тн)





**Баяжмал**

Салхит уулын баяжуулах үйлдвэр нь тайлант оны эхний хагас жилд мөнгө 11,185.71 гр/тн, алт 12.95 гр/тн агуулга бүхий 5,728.8 тн баяжмал үйлдвэрлэж, баяжмалын гарц 2.1%, металлын хэмжээ мөнгө 64.08 тн байхаар төлөвлөсөн. Баяжмалын металлын хувьд, мөнгөний металл авалт 81% байхаар төлөвлөсөн бол гүйцэтгэлээр:


- Мөнгөний металл авалт 81% буюу гүйцэтгэл 100%,
- Анхдагч хүдрээс 7,233 тн баяжмал үйлдвэрлэж, гүйцэтгэл 126%;
- Баяжмал дах мөнгөний агуулга 10,320.8 гр/тн буюу 92.27%, алтны агуулга 13.05 гр/тн буюу 100.75%;
- Баяжмалын металлын мөнгөний хэмжээ 75 тн буюу 117%-ийн гүйцэтгэлтэй байна.

Үзүүлэлт	Х/н	2024 оны эхний хагас жил			Үнэлгээ оноогоор
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Металл авалт (Ag)	%	81.0	81.0	100%	5
Үйлдвэрлэсэн баяжмал	тн	5,728.8	7,233	126%	5
Агуулга (Ag)	гр/тн	11,185.7	10,320.8	94%	4
Агуулга (Au)	гр/тн	12.9	13.1	101%	5
Металлын хэмжээ (Ag)	тн	64.1	75	117%	5
<b>Үнэлгээний дундаж оноо</b>					<b>4.8</b>


# “ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Үйлдвэрлэсэн баяжмал (тн)




Баяжмал дах металлын агуулга (гр/тн)




Баяжмал дах металлын хэмжээ



Үйлдвэрийн металл авалт, мөнгөний агуулга



## ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ МӨНГӨНИЙ АГУУЛГЫН ХАРЬЦУУЛАЛТ (ГР/ТН)



Хүдрийн шинж чанар өөрчлөгдөж, сульфидын агуулга ихэссэн

Үйлдвэрийн насжилтыг уртасгах

01

02

Хүдрийн эрдсийн шинж чанарыг сайжруулах

03

04

Хэт бага агуулгатай хүдрийг ашиглах, боловсруулах

Хүдрийн шинж чанараас хамаарсан баяжигдах чанарын технологийг сайжруулах

# “ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### Хаягдал

Тайлант хугацаанд хаягдал дах мөнгөний металл авалт 19%, хаягдлын гарц 97.9%, хаягдал дах мөнгөний агуулга 56.3 гр/тн, 15,031.3 кг мөнгөний хэмжээ бүхий 267.1 мян.тн хаягдалтай ажиллахаар төлөвлөсөн. Эхний хагас жилийн гүйцэтгэлээр:

- Хаягдал 321.2 мян.тн буюу 97.9%;
- Хаягдал дах мөнгөний хэмжээ 16.2 тн буюу 92%;
- Хаягдал дах мөнгөний агуулга 50.96 гр/тн буюу 112%;
- Хаягдал дах мөнгөний металл авалт 16% буюу 100%-ийн гүйцэтгэлтэй байна.


Үзүүлэлт	Х/н	2024 оны эхний хагас жил		Хувь	Үнэлгээ оноогоор
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Хаягдал					
Металл авалт	Ag, %	19.0	16	100%	5
Гарц	%	97.9	97.8	99.8%	4.9
Хаягдлын хэмжээ	мян.тн	267.1	321.2	97.9%	4.9
Металлын агуулга	Ag, гр/тн	56.28	50.96	112%	5
	Au, гр/тн	0.13	0.13	100%	5
Металлын хэмжээ	Ag, кг	15	16.2	92 %	4
<b>Үнэлгээний дундаж оноо</b>					<b>4.8</b>

Баяжуулах үйлдвэр нь бутлах хэсэг, нунтаглах хэсэг, флотацийн хэсэг, усгүйжүүлэх хэсэг зэрэг 4 үндсэн хэсгээс бүрдэж ажилладаг бөгөөд тайлант хугацаанд технологийн горим мөрдөн ажиллаж байна. Үйлдвэр тэжээж буй хүдрийн шинж чанар өөрчлөгдсөнөөс шалтгаалан үйлдвэрлэсэн баяжмалын агуулга 10,499.33 гр/тн буюу 94%-ийн гүйцэтгэлтэй гарсан. Үүний эсрэг компанийн удирдлагын зүгээс агуулга буурахад гарц өсгөх бодлого баримталсан ба үйлдвэрлэх баяжмалын хэмжээг сар бүр 3% өсгөж ажиллалаа. Гэхдээ баяжмалын агуулгыг 10,000 гр/тн-оос бууруулахгүй байх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Үйлдвэр тэжээж буй хүдрийн агуулгыг тогтмол хэмжээнд барихын тулд хүдрийн овоолгын харьцааг тогтмол хянаж ажилласан.
- Үйлдвэрийн төлөвлөгөөт бус зогсолтыг гаргахгүй байх арга хэмжээг авч ажиллаж байна.

Баяжмалын агуулга буурсан боловч үйлдвэрлэсэн баяжмалын хэмжээ гүйцэтгэлээр 7,233 (хуурай) тн буюу 126%, баяжмал дах металлын хэмжээ мөнгө 75 тн буюу 117% гүйцэтгэлтэй байна.

Баяжмалын өртөг




Баяжмалын агуулгыг тогтвортой түвшинд барихын тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Агуулгын түвшин өөр 3-4 ширхэг хүдрийн овоолгыг зохих харьцааны дагуу холих
- Эргэлтийн усны хатуулгийг багасгах
- Химийн бодисын зарцуулалтын харьцааг өөрчлөх
- Үйлдвэр тэжээж буй анхдагч хүдрийн нунтаглалтын хэмжээг (0.069) мм-т барих

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь 2024 оны эхний хагас жилд 6,200 тн баяжмал борлуулж 87.9 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллахаар төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 11,731.6 тн баяжмал борлуулж, 239.5 тэрбум төгрөг буюу 189%-ийн борлуулалтын орлоготой ажилласан.

Үзүүлэлт	Х/н	2024 оны эхний хагас жил			Үнэлгээ оноогоор
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Баяжмал борлуулалт	тн	6,200.0	11,731.6	189%	3
1 тн баяжмалын дундаж үнэ	\$/тн	5,838.0	6,250.5	107%	3
Нийт борлуулалт USD	мян.\$	36,643.3	70,453.0	192%	3
Нийт борлуулалт MNT	сая.₮	127,008.9	239,559	189%	3
<b>Үнэлгээний дундаж оноо</b>					<b>3</b>


### Хүдэр борлуулалт



■ Борлуулалтын орлого ( сая.₮)    - ● - Хүдэр борлуулалт ( тн)

94,552 сая.₮

### Баяжмал борлуулалт



■ Борлуулалтын орлого    - ● - Баяжмал борлуулалт

791,629 сая.₮

Салхит уулын баяжуулах үйлдвэр нь 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 90.1 тэрбум төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртөгтэй ажилласан. Баяжуулах үйлдвэр нь 328.4 мян.тн анхдагч хүдэр боловсруулсан. 1 тн баяжмалын борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 7,892 мянган төгрөг төгрөгөөр төсөвлөсөн бол гүйцэтгэлээр 7,679.4 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан. 2024 оны төсөвт Борлуулсан бүтээгдэхүүний өртөг нь нийт борлуулалтын орлогын 37.6%-тай тэнцүү байна.

Үзүүлэлт	Х/н	2024 оны эхний хагас жил		Хувь	Үнэлгээ оноогоор
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Тэсэлгээний ажлын зардал	сая.₮	5,130.0	4,433.2	86%	5
Уулын ажлын зардал	сая.₮	11,660.0	10,700.6	92%	5
1 тн хүдэр олборлолтын зардал	мян.₮	45.45	42.75	106%	5
БҮ-ийн 1 тн хүдэр боловсруулах зардал	1тн/₮	91,600	90,000	102%	5
1 тн баяжмал боловсруулах зардал	мян.₮	7,676.5	7,596.5	101%	5
<b>Үнэлгээний дундаж оноо</b>					<b>5</b>



# “ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК


## ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

### Ерөнхий удирдлагын зардал

Эхний хагас жилийн төлөвлөгөөгөөр нийт зардал 83,425.8 сая төгрөг, үүний 27.9% буюу 23,267.4 сая төгрөг нь ерөнхий удирдлагын зардал байхаар төсөвлөсөн. Тайлант хугацаанд ерөнхий удирдлагын зардал 21,300.4 сая төгрөг буюу 92%-ийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд энэ нь **нийт зардлын** 25.5%-ийг эзэлж байна.

Ерөнхий удирдлагын зардалд улсын төсөвт төлөх татвар хураамж 13,847.68 сая төгрөг буюу 65%-ийг, бараа үйлчилгээний бусад зардал 465.7 сая төгрөг буюу 4%-ийг, хангамж, бараа материалын зардал 2,038.4 сая төгрөг буюу 9.6%-ийг, эд хогшил, урсгал засварын зардал 79.0 сая төгрөг буюу 0.4%-ийг тус тус эзэлж байна.

Борлуулалтын орлогод эзлэх өртөг зардлын харьцаа (тэрбум.₮)



# “ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК

## ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

### Өөрийн хөрөнгийн өгөөж

2023 оны жилийн эцсийн санхүүгийн зарим үзүүлэлтийг 2024 оны эхний хагас жилийн үзүүлэлттэй харьцуулахад дараах байдалтай байна. Компанийн цэвэр ашиг 54% буюу 35.8 тэрбум төгрөг, нийт хөрөнгө 38.3 тэрбум төгрөг өссөн бол нийт өр төлбөр 63.7 тэрбум төгрөгөөр буурсан. Энэ нь эздийн өмчийг 102.1 тэрбум төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн ба цэвэр хөрөнгийн өгөөж 71%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

Үзүүлэлт	12/31/2023	6/30/2024	Зөрүү	%
Цэвэр ашиг	66,330	102,141	35,811	54%
Нийт хөрөнгө	1,104,579	1,142,926	38,347	3%
Нийт өр төлбөр	(1,062,689)	(998,893)	63,796	-6%
Эздийн өмч (цэвэр)	41,890	144,033	102,143	244%
ROE	158%	71%	-	-

### Нийт хөрөнгийн өгөөж

2024 оны эхний хагас жилд тооцсон нийт хөрөнгийн өгөөжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай харьцуулахад нийт хөрөнгийн өгөөж 3 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Үзүүлэлт	12/31/2023	6/30/2024	Зөрүү	%
Цэвэр ашиг	66,330	102,141	35,811	54%
Нийт хөрөнгө	1,104,579	1,142,926	38,347	3%
ROA	6%	9%	3%	-

## ӨР ТӨЛБӨР, ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХАРЬЦААНЫ БИЕЛЭЛТ

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт өр 1,062.6 тэрбум төгрөгөөр тайлагнаж байсан бол 2024 оны эхний хагас жилийн байдлаар 998.9 тэрбум төгрөгийн буюу 63.8 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Үзүүлэлт (сая төгрөг)	12/31/2023	6/30/2024	Зөрүү	%
Дансны өглөг	4,739	7,319	2,580.8	54%
Цалингийн өглөг	-	363	363.4	100%
Татварын өр	95,990	79,931	-16,059.4	-17%
НДШ-ийн өглөг	-	24	23.8	100%
Урьдчилж орсон орлого	80,286	30,155	-50,131.5	-62%
Бусад богино хугацаат өр төлбөр	1,926	1,354	-572.3	-30%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	182,941	119,146	-63,795.1	-35%
Урт хугацаат нөөц (өр төлбөр)	2,415	2,415	0.0	0%
Бондын санхүүжилтийн өглөг	877,333	877,333	0.0	0%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	879,748	879,748	0.0	0%
Өр төлбөрийн нийт дүн	1,062,689	998,894	-63,795.1	-6%
Богино хугацаат өр төлбөр	17%	12%	-	-
Урт хугацаат өр төлбөр	83%	88%	-	-

Компанийн богино хугацаат өр төлбөр 6%-иар буурсан. Үүнд нөлөөлөх хүчин зүйл нь өмнөх онуудад хуримтлагдсан татварын өр төлбөрийн 17%-ийг барагдуулсан, урьдчилж орсон орлогын 62%-ийг борлуулалтаар хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна. Богино хугацаат өр төлбөр 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт өр төлбөрийн 17% урт хугацаат өр төлбөр 83%-ийг эзэлж байсан бол 2024 оны эхний хагас жилийн байдлаар богино хугацаат өр төлбөр 12% урт хугацаат өр төлбөр 88%-ийг эзэлж байна. Урт хугацаат өр төлбөр хэсэгт *“Төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК нь өөрийн охин компанийн эзэмшлийн Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалан үнэт цаас гаргах замаар иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн тодорхой хэсгийг төлнө”* гэж заасны дагуу Эрдэнэс 1 бондын төлбөр болох 877.3 тэрбум төгрөгийг санхүүгийн тайланд бүртгэгдсэнтэй холбоотой юм.


# “ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК

## ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ


### Бараа материалын нөөцийн удирдлагын гүйцэтгэл

Тайлант онд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны гол нөөцүүд болох хүдрийг 52,300 тн/сар, баяжмалыг 1,100 тн/сар байхаар төлөвлөсөн. Бараа материалын нөөцийн бэлэн байдал 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар зорилтот түвшнийг дараах байдлаар ханган ажиллаж байна.

Боловсруулсан хүдэр (тн)



Үйлдвэрлэсэн болон борлуулсан баяжмал /тн/



■ Үйлдвэрлэл (гүйцэтгэл)    - - - Борлуулсан баяжмал


### Өр төлбөр, авлагын удирдлагын гүйцэтгэл

Тайлант оны эхний хагас жилийн байдлаар санхүүгийн тайлангийн өглөг, авлагын насжилттай холбоотой хугацаа хэтрэлтгүй ажиллаж байна.


Үзүүлэлт	12/31/2023	6/30/2024	Зөрүү	%
Дансны авлага	676	11,661	10,984.8	1626%
Татвар, НДШ-ийн авлага	1,522	1,522	0.0	0%
Бусад авлага	202	264	62.5	31%
<b>Нийт</b>	<b>2,400</b>	<b>13,447</b>	<b>11,047</b>	-

Дансны авлагын 11,6 тэрбум төгрөг нь II улирлын баяжмалын ачилттай холбоотой юм. Компанийн санхүүгийн хэлтэс нь өр төлбөрийн дансны үлдэгдлийг тухай бүр тооцоо нийлэн ажиллаж байна.

Цэвэр ашиг ( тэрбум.₮)




Нэг ажилтанд ногдох цэвэр ашиг (сая.₮)



## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Компанийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр батлуулсан ба нийт **137 тэрбум** төгрөгийн төсөвт өртгөөр 121 төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Худалдан авах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

Компанийн 2024 оны худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөний дагуу хагас жилийн байдлаар нийт **123.7 тэрбум** төгрөгийн төсөвт өртөгтэй 54 тендер шалгаруулалтыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д нийцүүлэн олон нийтэд нээлттэй зарласан бөгөөд үүнээс **59.6 тэрбум** төгрөгийн төсөвт өртөгтэй 30 тендер шалгаруулалт амжилттай болсон байна. Түүнчлэн **416 сая** төгрөгийн шууд худалдан авалт хийж, **131 сая** төгрөгийн ерөнхий гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг үр ашигтай, ил тод, ашиг сонирхлын зөрчилгүй, түргэн шуурхай зохион байгуулан ажилласан.



## СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль”- ийн хэрэгжилтийг хангаж ажиллах зорилгын хүрээнд Салхитын мөнгө-алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотой бараа, ажил, үйлчилгээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны мн-59/39 дүгээр зөвлөмжид үндэслэн 2020-2022 онд шууд худалдан авалтын журмаар худалдан авсан. Салхитын мөнгө-алтны ордын үйл ажиллагаа жигдэрсэн тул холбогдох худалдан авалтуудыг 2023 оноос эхлэн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулан ажиллаж байна.

Сүүлийн 3 жилийн хөрөнгө оруулалтын мэдээлэл

Хоёр компанийг нэгтгэх үйл ажиллагаа нь 3 сарын турш үргэлжилсэн ба энэ хугацаанд тендер шалгаруулалттай холбоотой бүх ажлуудыг хойшлуулсан бөгөөд “Овоот хяр” төсөлтэй холбоотой бүх хөрөнгө оруулалтыг 2024 он руу шилжүүлсэн.




■ Батлагдсан төсөв

■ Гүйцэтгэл


Мөнгөний агуулга 56.5 гр/тн, алтны агуулга 0.15 гр/тн агуулга бүхий хаягдлыг боловсруулан эдийн засгийн эргэлтэд оруулснаар **үйлдвэрийн насжилтыг 5 жилээр уртасгах боломж бүрдэнэ.**

Дунджаар жилд 10 мян.тонн баяжмал үйлдвэрлэнэ. Баяжмал дахь мөнгөний агуулга дунджаар 6,000 гр/тн , алтны агуулга дунджаар 0,05 гр/тн байна.

Хаягдлын хэмжээ(мян.тн)



Эдийн засгийн үзүүлэлтийн төсөөлөл (тэрбум.₮)





# “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн алтны геологи, хайгуулын төсөл

## Салхит төсөл – Мөнгө, алт

### □ Ерөнхий мэдээлэл

#### Байршил:

Улаанбаатар хотоос 280 км-ын зайтай Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт.

Лиценз №: MV-021483

Талбайн хэмжээ: 2,887.9 га

Хайгуул хийгдсэн талбай: 450 га талбайд хайгуулын ажил, 1250 га талбайд талбайн зураглал

Хөрөнгө оруулалт: 2020-2024 ХБГ 8.8 тэрбум төгрөг

### □ Геологи, хайгуулын ажил

2021 онд эрэл-үнэлгээний ажлыг гүйцэтгэж 1.6 сая.тн хүдэрт 0.66 гр/тн-ы дундаж агуулгатай 1.3 тн алтны таамаг баялаг тогтоосон.

Нөөцийн шинэчилсэн тооцоог ЭБМЗ-р 2024 оны 07-р сарын 05-ны өдөр хэлэлцүүлэн батлуулсан.

В+С зэрэглэлийн 1.8 сая тн хүдэрт 106.9 гр/тн-ын дундаж агуулгатай 191.2 тн мөнгө, 0.28 гр/тн-ы дундаж агуулгатай 502.7кг алтны нөөцийг тогтоосон

2024 онд Зүүн эрлийн талбайд 4,500 тууш метр өрөмдлөгийн ажил гүйцэтгэсэн


### Ерөнхий төлөвлөгөө

2024	2025	2026	2027
“Зүүн” эрлийн талбайд геологи, хайгуулын ажил хийж гүйцэтгэх	“Баруун-1”, “Баруун-2” эрлийн талбайд геологи, хайгуулын ажил хийж гүйцэтгэх	“Нарийн” эрлийн талбайд геологи, хайгуулын ажил хийж гүйцэтгэх	<ul style="list-style-type: none"><li>Урьдчилсан ТЭЗҮ боловсруулах, Тайланд шинжээч томилуулах Нөөцийн хуралд бүртгүүлэх</li><li>ЭБМЗ-ийн хурлаар нөөц батлуулах</li></ul>

# “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн алтны геологи, хайгуулын төсөл

## Хүрэнцав төсөл – Алт

### □ Ерөнхий мэдээлэл



**Хөрөнгө оруулалт:** 2021-2023 онд 1.4 тэрбум төгрөг

### □ Геологи, хайгуулын ажил

- ✓ “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн захиалгаар Геологи, судалгаа-шинжилгээний төвөөр хүдрийн дээжийг баяжуулах технологи туршилт, судалгааны ажил хийлгэсэн.
- ✓ Хайгуулын талбайн хэмжээнд Гедрогеологийн ажлыг хийж гүйцэтгэсэн.
- ✓ Хүрэнцав төслийн урьдчилсан ТЭЗҮ боловсруулах сонгон шалгаруулалт хийж, ажлыг эхлүүлсэн.
- ✓ Хүрэнцав төслийн БОННУ-ний тайлан боловсруулж дууссан. БОАЖЯ-ны мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.

- Хайгуулын талбайд хийгдсэн судалгаагаар 5 тусдаа хүдрийн биет илрүүлж **0.7 гр/тн** алтны дундаж агуулгатай **P2 зэрэглэлийн 5.3 сая тонн хүдрийн нөөцтэй, 3,700 кг алтны баялаг** урьдчилсан байдлаар илрүүлсэн.
- Нөөцийг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр бэлдэж байна.. Цаашид нөөц нэмэгдэх бүрэн боломжтой.

Ерөнхий төлөвлөгөө		
2024	2025-2026	2027
Геологи, хайгуулын ажил Батлагдсан төсөв: 9.7 тэрбум төгрөг		Уурхайн үйл ажиллагаа эхлүүлэх
БОННУ, урьдчилсан ТЭЗҮ, технологи туршилтын ажил	2024-2025 оны хайгуулын ажлын нөөцийг ЭБМЗ-ийн хурлаар батлуулах	Нэмэлт хайгуул
2021-2022 оны хайгуулын ажлын нөөц батлуулах	ТЭЗҮ, БОННУ	

# “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн алтны геологи, хайгуулын төсөл


## Овоот хяр төсөл – Алт

### □ Ерөнхий мэдээлэл

**Байршил:** Улаанбаатар хотоос 700 км-ын зайтай Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт.

**Лиценз №:** XV-021670

**Талбайн хэмжээ:** 22,641.51 га



**Хайгуул хийгдсэн талбай:** 386 га талбайд нөөц тогтоосон. 3650 га талбайд эрэл үнэлгээний ажил хийсэн.

**Хөрөнгө оруулалт:** 2020-2024 ХБГ 18 тэрбум төгрөг

**“Овоот хяр” талбайд** гүйцэтгэсэн 2020 оны хайгуулын ажлын үр дүнгээр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл “Хойд бүргэд” алтны үндсэн ордын нөөцийг Бодитой болон Боломжтой (В+С) зэргээр тооцон 53.1 тн алтны нөөцийг улсын бүртгэлд бүртгэсэн.

### □ Геологи, хайгуулын ажил

- ✓ Хойд Бүргэд алтны үндсэн ордод ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэхээр баримт бичийг бүрдүүлж байна. Хойд Бүргэд алтны үндсэн ордод Нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах сонгон шалгаруулалтын ажил хийгдэж байна.
- ✓ Хайгуулын тусгай зөвшөөрлийн хэмжээнд агаар сансарын зургийн ажлыг гүйцэтгэж, тайланг хүлээн авсан.
- ✓ Төслийн талбайд геофизикийн ажил гүйцэтгэсэн.

### Ерөнхий төлөвлөгөө

2024	2025	2026	2027
“Овоот хяр хойд” эрлийн талбайд геологи хайгуулын ажил гүйцэтгэх	“Зүүн Бүргэд” эрлийн талбайд Нэмэлт хайгуул хийх	“Төв-Өмнөд Бүргэд” эрлийн талбайд геологи хайгуулын ажил гүйцэтгэх	“Төв-Өмнөд Бүргэд” эрлийн талбайд нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх

## Уурхайн хэмжээнд ХАБЭА-н үзүүлэлтүүд

/2024 оны эхний хагас жилийн байдлаар/



949,469

хүн цаг



182

хоног



0

осол дөхсөн  
тохиолдол



0

ҮОХХ

ХАБЭА-н зөрчлөөс  
шалтгаалсан сул  
зогсолтын хугацаа

0

Аюултай  
нөхцөл  
байдал

0

Үйлдвэрийн  
осол, хурц  
хордлого

0

Аюултай  
тохиолдол

0

Осол  
дөхсөн  
тохиолдол

0

Аюултай  
үйлдэл

0

# “ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК

## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

### ХАБЭА-н дадал, хэвшил

#### Хөдөлмөрийн Аюулгүй Байдлын манлайлал, оролцоог идэвхжүүлэх ажлын хүрээнд:

Хөдөлмөрийн аюулгүй байдалд хандах хувь хүний хандлагыг өөрчлөх, ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх үүднээс үйлдвэрлэлийн орчин, ажиллах нөхцөлийг сайжруулах, ажилтныг ажлын байр дах осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл болон бусад эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх, ажлын байрны соёлыг төлөвшүүлэхэд жил бүрийн 04 дүгээр сард ХАБЭА-н сарын аяны хүрээнд нийт ажилтнуудад харилцаа хандлага, галын аюулгүй байдал, гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтыг “Монголын цахим институт”-аас авч ажилласан.

Тайлант оны эхний хагас жилд урьдчилсан зааварчилгаанд 292 ажилтан, зочдын зааварчилгаанд 45 иргэн, ХАБЭА-н сургалтад 120 ажилтнууд, ажлын байрны давтан зааварчилгаанд 354 ажилтан тус тус хамрагдаж, нийт 949,442 хүн/цаг зарцуулан зохион байгуулж ажилласан байна. ХАБЭА-н инженерийн ерөнхий хяналт дор Баяжмал ачилтын давтан зааварчилгааг “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн 48 ажилтан, баяжмал тээвэрлэх компанийн 25 менежер болон жолооч, ажилтнуудад тус тус өгч ажилласан.

### ХАБЭА-д зарцуулсан зардлын биелэлт

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2024 эхний хагас жил		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
ХАБЭА-н нийт зардал	730.7	447.2	62%

### Байгаль орчны зөрчлийн үнэлгээ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дагуу жил бүрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд Байгаль орчин, аялал жуулчлалын ямаар хянуулан батлуулж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2020-2023 оныг дуустал Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнүүлсэн байдлыг доорх хүснэгтэд харуулав. **Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын ямаар 2024 оны I улиралд багтаан батлуулсан болно.**

### Ус ашиглалтын тайлангийн үнэлгээ

Жил бүрийн ус ашиглалтын тайланг Усны газар, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа, Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газруудад тус тус хүргүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2023 оны Ус ашиглалтын тайланг хуулийн хугацаанд хугацаанд хүргүүлж, дүгнүүлэн ус ашиглах гэрээ дүгнэсэн актыг гаргуулж авсан. Ус ашиглалттай холбоотой дараах бичиг баримтуудыг хуулийн хугацаанд албажуулсан: Үүнд:

1. Ус ашиглуулах дүгнэлт- Усны газар
2. Ус ашиглалтын тайлан – Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа
3. Ус ашиглах гэрээ - Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа
4. Ус ашиглах гэрээ дүгнэсэн акт - Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	2020	2021	2022	2023	2024 Эхний хагас жил
Орон нутгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр дүгнүүлсэн хувь, гүйцэтгэл	90.1%	91.4%	92.4%	100%	70%

# “ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК

## БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



### Нөхөн сэргээлтийн байдал

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь Орон нутагтай хамтран ажиллах гэрээний дагуу Нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах **“Буурал”** нэртэй хууль бусаар ухагдаж эвдрэлд орсон, **эзэн холбогдогчгүй талбайд** хэрэгжүүлэхийг санал болгосны дагуу 2024 онд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөсөн хэмжээнд бүрэн хийж орон нутагт актаар хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн. Уг ажлын зардалд тооцооллоор **35,000,000** төгрөгийн зардал гарахаар төлөвлөгдсөн.

Тайлант онд нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд салхит уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан ашиглалтын хугацаа ойртож байгаатай холбоотойгоор орон нутгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй зөвшилцөж тус онд **салхит уурхайн өөрийн эдэлбэр газарт явцыг нөхөн сэргээлтийг** хийж гүйцэтгэхээр тус тус төлөвлөсөн.

Явцын нөхөн сэргээлт хийх шаардлагатай, **дахин ашиглагдахгүй болсон газруудыг тодорхойлж** маркшейдерийн хэмжилтээр тооцоо, судалгааг хийж түүнд зарцуулагдах зардлыг тодорхойлсон.

### Салхитын мөнгө-алтны ордын Хаалтын менежментийн төлөвлөгөөнөөс 2024 онд хийж гүйцэтгэх нөхөн сэргээлтийн ажил

Төлөвлөгдсөн 5.6 га талбайн газар хэлбэршүүлэлтэд 56,000 м<sup>3</sup> газар шорооны ажил хийх шаардлагатай. Мөн чулуулгийн овоолгын дээд хэсэгт борооны ус болон гадаргын усны урсцыг чулуун хуягт суваг руу чиглүүлэх зорилгоор тодорхой хэмжээний налуутай байхаар төлөвлөж байна. Мөн 0.58 га талбайд 40 м<sup>3</sup> хаягдал хөрс дэвссэний дараа 0.25-0.3м шимт хөрс дэвсэж, хөрс боловсруулалт, сайжруулалт гүйцэтгэж нутгийн үетэн, буурцагтан ургамал болон таанын үрээр ургамалжуулна.

### Мод тарих, ойн санг нэмэгдүүлэхээр ажилласан байдал

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилтийг сааруулах, ой, усны нөөцийг хамгаалахад хувь нэмэр оруулах зорилгоор “Эрдэнэс алт ресурс” ХХК нь нийт туслан гүйцэтгэгч компаниудтайгаа хамтран 2024 оны Хаврын бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүдээр буюу 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрүүдэд Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д 50000 ширхэг хайлаас мод, Богдхан уулын дархан цаазат газрын Чандманы аманд нийт 2000 ширхэг 3-5 настай шинэс модны суулгацыг тарих ажлыг тус тус зохион байгуулж ажилласан.

№	Үзүүлэлт	Асуудал	Хэрэгжилтийн хувь
1	Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн тогтоол	7	100%
2	Эрдэнэс алт ресурс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгавар	3	100%
3	Эрдэнэс Монгол ХХК-иас өгөгдсөн үүрэг даалгавар	30	98.3%
4	Маргаан, зөрчил, гомдол тэдгээрийг шийдвэрлэсэн байдал	8	100%

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

### Дотоод аудитын зөвлөмж, эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал

Компанийн шинэчлэгдсэн бүтэц зохион байгуулалтаар Дотоод хяналтын албанд Эрсдэлийн болон Хяналтын мэргэжилтнүүд ажиллаж, үндсэн чиг үүргийн хүрээнд компанийн үйл ажиллагааг зөв зохион байгуулахад, хүний нөөцийн болон үйлдвэрийн технологийн хяналтын систем, эрсдэлийн удирдлага, хяналтын үйл ажиллагааг бий болгох төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн Гүйцэтгэх захирлын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/144 дугаартай тушаалаар **“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн 2024 оны I улирлын үйл ажиллагаанд хэсэгчлэн аудитын шалгалт хийж, холбогдох дүгнэлтийг 05 дугаар сарын 17-ны өдрийн дотор танилцуулах** үүрэг даалгаврыг Дотоод аудиторүүдэд өгсөн бөгөөд тус үүрэг даалгаврын дагуу компанийн I улирлын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч ажилласан. Цаашид эхний хагас жилийн үйл ажиллагаанд хэсэгчлэн аудитын шалгалт хийж, холбогдох дүгнэлтийг гаргахаар ажиллаж байна.



# “ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК

## ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНГИЙН ЖИЛ-ОНЦЛОХ АЖИЛ

№	Онцлох ажлууд	Хувь
1	Хүдрийн агуулгаас шалтгаалж буурсан <b>баяжмалын агуулгыг төлөвлөсөн түвшинд</b> хүргэж ажилласан.	100%
2	Салхит мөнгө-алтны ордын төвийн бүсэд бүсэд <b>гүйцээх хайгуул хийсэн талбайн нөөцийг ЭБМЗ-р батлуулсан.</b> (Ашиглалтын үед зөрж байсан нөөцийн блокуудын зөрүүг арилгасан.)	100%
3	Салхит уулын баяжуулах үйлдвэрийн хэрэглээний усны хомсдолоос болж зогссон байсан 2 дугаар үйлдвэрийн <b>2 дах шугамыг төлөвлөгөөт хугацаанаас өмнө бүрэн ажиллагаанд оруулсан.</b>	100%
4	Үйлдвэрлэлийг жигд явуулахад шаардлагатай байсан цэвэр усны хэрэглээг хангахын тулд <b>шинээр 100 метрийн гүнтэй 2,5 л/сек-ийн ундаргатай зөөврийн 2 худгийг ашиглалтад оруулсан.</b>	100%
5	Үндэсний <b>аудитын</b> газраас 2023 оны санхүүгийн тайланд <b>аудит баталгаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.</b>	100%
6	Салхит уулын баяжуулах үйлдвэрийн хаалтын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу <b>хаягдлын овоолгыг хэлбэржүүлж, техникийн нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлсэн.</b>	100%
7	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлын хүрээнд зэрлэг амьтдын нөөцийн хомсдолыг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах зорилгоор нийт <b>100 толгой тарвагыг Их газрын чулуу байгалийн цогцолборт газарт нутагшууллаа.</b>	100%
8	"Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр", "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилтийг сааруулах, ой, усны нөөцийг хамгаалахад хувь нэмэр оруулах зорилгоор тайлант хугацаанд Салхит уурхайн <b>“Эрдэнэс төгөл”-д 50,000 ширхэг хайлаас мод, Богдхан уулын дархан цаазат газрын Чандманы аманд нийт 5555 ширхэг 3-5 настай шинэс модны суулгацыг</b> тарих ажлыг тус тус зохион байгууллаа.	100%

№	Онцлох ажлууд	Хувь
9	Өвлийн цасан шуурга <b>байгалийн аюулт үзэгдлийн үед</b> Дундговь аймгийн Гурвансайхан сум, чулуут багийн нутагт орших Салхитын мөнгөний уурхайн эргэн тойронд эргүүл жижүүр ажиллуулж малчдад дэмжлэг туслалцаа үзүүлэн ажилласан. Цаг агаарын нөхцөл хүндэрсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд <b>нийт 27 иргэний амь насыг аварсан.</b>	100%
